

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

4-16

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

4-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 01-ний өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 40 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, Б.Заяабал, С.Одонтуяа;

Чөлөөтэй: Б.Энхбаяр;

Тасалсан: Х.Баттулга, Л.Мөнхбаатар, У.Отгонбаяр, Х.Тэмүүжин.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны ахлах мэргэжилтэн Б.Галсанбат, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг дахин явуулах талаар танилцуулав.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг үндэслэн хаалттай горимд шилжин хуралдав./12:43/

13 цаг 08 минутаас нээлттэй горимд шилжин хуралдав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатар, П.Сайнзориг, Дав.Цогтбаатар нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 16.1.1.7 дахь хэсгийн Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, 4 эгнээ, 113,1 км

гүүрэн байгууламж, 885,6 урттай /төвийн бүс/, төсөвт өртөг 630 тэрбум 587,5 сая төгрөг, санхүүжих дүн 104 тэрбум 646,9 сая төгрөг гэсэн энэ төсөл, арга хэмжээний дүнгээс 39 тэрбум 951,5 сая төгрөгөөр бууруулж, дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх. Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын 15.3.1-д Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 15 тэрбум 275,1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх;

-Дүүргийн Эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12 тэрбум 801 сая төгрөг, санхүүжих дүн 5 тэрбум 120,4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 4 тэрбум 452,3 сая төгрөг, санхүүжих дүн 1 тэрбум 780,9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Дархан-Уул аймаг шүүхийн барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12 тэрбум 320 сая төгрөг, санхүүжих дүн 4 тэрбум 928 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025 -2026 он, төсөвт өртөг 8 тэрбум 674,7 сая төгрөг, санхүүжих дүн 3 тэрбум 469,9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8 тэрбум 674,7 сая төгрөг, санхүүжих дүн 3 тэрбум 469,9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2013-2026 он, төсөвт өртөг 44 тэрбум 552,4 сая төгрөг, санхүүжих дүн 15 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Улсын прокурорын урсгал зардлыг 1,1 тэрбум 182,4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, П.Сайнзориг, С.Эрдэнэболд, Б.Жавхлан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг “дэмжсэнээр” тооцов.

Уг асуудлыг 13 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 43 минут үргэлжилж, 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
12 цаг 40 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаан эхэлж байна.

Энэ хуралдаанд ирэх ёстой гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн байгаа тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирцийг би танилцуулъя. Ирц Цогтбаатар, Алдаржавхлан, Алтанхуяг гишүүн, Баасанжаргал, Бат-Эрдэнэ, Ганбат, Нарантуяа-Нара, Номинчимэг, Пүрэвдорж, Сайнзориг, Сандаг-Очир, Уянгахшиг, Да.Цогтбаатар, С.Эрдэнэболд гэсэн энэ гишүүд ирснээр хурал 59,1 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсөв төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл. Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, энэ 2 дахь хэлэлцүүлгийг дахин явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын

хороонд хүргүүлнэ гэсний дагуу бид нар энэ хурлыг хийж байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудал маань бол ийм байгаа.

Урьд өмнө зарчмын зөрөөтэй санал гаргаж би тодорхой эх үүсвэрээс төсөв дээр санал гаргасан байгаа. Одоо буцаад орж ирэхдээ бид нар эх үүсвэрээ бол өөрчилсөн байгаа. Энд оруулж ирж байгаа эх үүсвэр өөрөө улсын шууд нууцтай холбоотой энэ эх үүсвэрээс бид нар оруулж байгаа учраас хуралдаан хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.2-т заасны дагуу хуралдааныг хаалттай явуулна.

Хаалттай горимдоо шилжье./12:43/

НЭЭЛТТЭЙ ГОРИМД ШИЛЖСЭН ХУРАЛДААН.

Д.Цогтбаатар: Одоо ажлын хэсэг орж ирэх боломжтой болно.

Байнгын хорооныхоо хурлыг үргэлжлүүлье.

Сая би хаалттай горимоор энэ эх үүсвэрийнхээ асуудлыг танилцууллаа. Эх үүсвэр нь өөрөө хаалттай горимоор хэлэлцэх журамтай ийм эх үүсвэр байсан учраас хурлыг хаалттай горим руу шилжүүлээ.

Тэгээд сая гишүүдтэйгээ ярьж байгаад энэ эх үүсвэрийг хаалттай эх

үүсвэр биш өөр эх үүсвэрээс сольж оруулахаар болж байна.

Тийм учраас хурлыг нээлттэй горимд шилжүүлээд ингээд би зарчмын зөрөөтэй шинэ саналын томъёогоо уншиж танилцуулъя. Одоо би өөрчилсөн юу, саналын томъёогоо унших гэж байна.

Төслийн 2 дугаар хавсралтын 14.1.1.7 дахь хэсгийн Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, 4 эгнээ, 113,1км гүүрэн байгууламж, 885,6 уртай юу, төвийн бүс, төсөвт өртөг 630 тэрбум 587,5 сая төгрөг, санхүүжих дүн 104 тэрбум 646,9 сая төгрөг гэсэн энэ төсөл, арга хэмжээний дүнгээс дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх.

Энд төслийн 2 дугаар хавсралтын 15.3.1-д Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг санхүүжих дүн 15 тэрбум 275,1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх.

Дүүргийн Эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн барилга, Улаанбаатар, БЗД, хэрэгжих хугацаа 2025-2027 он. Төсөвт өртөг 12 тэрбум 801 сая төгрөг. Санхүүжих дүн 5 тэрбум 120,4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга, Өмнөговь Даланзадгад сум, хэрэгжих хугацаа 2025-2027 он. Төсөвт өртөг 4 тэрбум 452,3 сая төгрөг, санхүүжих дүн 1 тэрбум 780,9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Дархан-Уул аймаг Шүүхийн барилга, Дархан-Уул Дархан сум, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 12 тэрбум 320 сая төгрөг, санхүүжих дүн 4 тэрбум 928 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Багануур дүүрэг дэх шүүхийн барилга, Улаанбаатар Багануур дүүрэг, хэрэгжих хугацаа 2025 -2027 он. Төсөвт өртөг 8 тэрбум 674,7 сая төгрөг, санхүүжих дүн 3 тэрбум 469,9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Архангай аймаг дахь шүүхийн барилга, Архангай Эрдэнэбулган сум, хэрэгжих хугацаа 2025-2027 он, Төсөвт өртөг 8 тэрбум 674,7 сая төгрөг, санхүүжих дүн 3 тэрбум 469,9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Одоо тараая. Яагаад гэвэл нөгөө нууцын горимоос гарчихсан учраас. Үгүй ээ.

Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр, Улаанбаатар Хан-Уул дүүрэг, хэрэгжих хугацаа 2013-2026 он, төсөвт өртөг 44 тэрбум 552,4 сая төгрөг, санхүүжих дүн 15 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Улсын прокурорын урсгал зардлыг 1,1 тэрбум 182,4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар гэсэн ийм томъёололтой зарчмын зөрөөтэй санал гаргаж байна.

Тэгэхээр би хэдээр бууруулахаа бас тодотгож хэлэх ёстой.

Төслийн 2 дугаар хавсралтын 16.1.1.7 дахь хэсгийн Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөлийн энэ 4 эгнээтэй замаас бууруулах дүн нь 39 тэрбум 951,5 сая төгрөгөөр бууруулахаар ингэж санал оруулж байгаа шүү.

Тэгэхээр энэ дээр би бас нэг тодотгол хийх ёстой юм байна. Энэ дээр сая уншигдаж оруулсан, нөгөө саналууд дээр 25-27 он гэсэн хугацаанууд юу, шүүхийн байрууд дээр орж ирсэн байна. Тэгэхээр үүнийг протоколд 25-26 он гэж тэмдэглэж аваарай.

Энэ Өмнөговь дахь шүүхийн барилга мөн түүнчлэн Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилга 25-26 он, Багануур дүүрэг дэх шүүхийн барилга 25-26 он гэсэн ингэж тодотгол бас хийж өгч байна шүү.

Бас энд нэг протоколд зүйлийг тэмдэглэж үлдээхийг энэ төслийн Төсвийн байнгын хорооноос санал болгож байна. Энэ санал болгож байгаа бүх төслүүд төсөв, зурагтайгаа төсвүүд байгаа шүү. Төсөв, зураггүйг нь эндээс ялгаад хассан байгаа гэдгийг бас эхнээс нь тодотгоод хэлчихье ээ. Протоколд үлдэх ёстой.

Баярлалаа.

Ингээд энэтэй холбогдуулаад, саналтай холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алтанхуяг гишүүнээр тасаллаа.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Би гаргаж байгаа зарчмын саналыг дэмжиж байгаа. Тэгээд өнөөдөр бас 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг

амилуулж, шүүхийн хуулийг батлуулахад бас оролцож байсан хүмүүс энэ танхимд сууж байна. Түүрүүн дурдах юм бол Алтанхуяг гишүүн, Сандаг-Очир гишүүн бас ингээд байж байна. Манай Ганбат гишүүн дэмжээд явж байсан.

Тэгээд бас энэ хуулийн маань хэрэгжилт бас энэ шүүхийн дэд бүтцийн асуудал буюу энэ үйлчилгээ үзүүлэх, энэ байр савны асуудал дээр очоод бас хүндрэлтэй байсан нь үнэн. Олон жил бас энэ асуудал бас тулгамдаж байгаа.

Тэгээд энэ удаагийн Засгийн газар Сангийн яам маань бас энэ дээр нэлээн томоохон дорвитой санхүүжилтийг олгож, бас энэ шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, энд бас ерөөсөө л цаана нь хүний эрхийн асуудал байгаа.

Тэгэхээр энэ шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй авах, эргээд энэ нэг айдасгүй магадгүй яг хэргийн оролцогчид бие биеийнхээ нүүрийг хараад сууж байгаа шүү дээ. Яаж мэтгэлцэх вэ дээ.

Тэгэхээр энэ бүх нөхцөл байдлуудыг бас ойлгож, хөрөнгө оруулалтыг шийдэж өгч байгаад талархаж байна. Тэгээд 19 оны энэ өөрчлөлтийг бид нар бас яг бодит болгох энэ алхмууд хийгдээд явж байгаад бас сайшаалтай байна.

Тэгээд гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Тэгээд энэ ажил дээр идэвхийлэн оролцож байгаа Байнгын хорооны даргад бас талархаж байна. Тэгээд мэдээж энэ шүүх бүхий үйл ажиллагааг нэг энэ удаагийн төсвөөр шийдэхгүй. Ер нь цаашидаа анхаарах юмнууд байна.

Тэгээд энэ дээрээ бас хууль, эрх зүйн орчноо сайжруулаад ойлголцоод явах нь зөв байна гэдэг зүйлийг энэ таширамд хэлмээр байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Юу байна л даа. Энэ асуудлыг тусгайлан Хууль зүйн байнгын хороо хуралд аа гээд Улсын Их Хурлын үүрэг чиглэл өгөөд, бид нар чинь цаг гаргаж өгөөд ингээд байна л даа. Одоо Улсын Их Хурал хүлээгээд сууж байна. Бүх юмыг бид нар хуулийн дагуу л явуулах ёстой. Хуулийн дагуу явуулаач ээ гэдэг хүсэлтийг миний бие гаргасан байгаа.

Ингээд харж байхад шүүх засаглал, шүүх өөрөө хараат бус байх ёстой. Энэ Монгол Улсын хуульд бүгдийг нь заагаад өгчихсөн байгаа. Энэ процесс, энэ юм хум бол шүүхийн төсөв хараат байх, хараат бус байх бас нэг зүйл, хуулийн зүйл заалттай. Энэ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс өгсөн, мэдүүлсэн, Сангийн яам нь авч хэлэлцсэн, Хууль зүйн байнгын хороогоор ярилцсан энэ тэр бол бүгд хуулийн дагуу явчхаад байгаа байхгүй юу. Үүнээс цаашаа бол Улсын Их Хурлаар батлаад л гарах ёстой байтал Төсвийн байнгын хороо дээр хуулиа анзаарсангүй юу, яасан, бас нэг ийм зөрчил гарчихжээ. Тэгэхээр би, Шүүхийн ерөнхий зөвлөлийг тэр хуулийн зүйл заалтыг тайлбарлаж өгөөч ээ гэж хүсэж байна, 1 дүгээрт.

2 дугаарт, нэгэнт энэ ажлыг хийж байгаа юм чинь энэ 25 ондоо дуусгасан нь дээр ээ. Би Цогтбаатар даргын санал дээр өмнө нь гаргасан саналыг чинь дэмжье ээ. Эхний санал. Тэр бол хуулийн дагуу явчихсан байсан. Одоо бол 2 он дамнуулаад хийх гээд байгаа. Үүнийгээ больчих оо. Энэ ондоо багтаагаад л тэр 70 тэрбумыг нь

тусгаж өгөөд, ажлыг нь дуусгуул гэсэн ийм саналтай байна.

Нөгөө талаараа энэ олон жилийн түүхэнд Монгол Улсын шүүх нэг ч гэсэн өөрийн байр байхгүй, зориулалтын. Тэр байтугай Дарханд, Оросын Холбооны Консулын байранд байрлаж байгаа гэж би дуулсан. Ийм байж болохгүй байхгүй юу. Энэ үнэн үү? Үүнийг бас тодруулж асуумаар байна. Ер нь шүүхийн байрны нөхцөл ямар байгаа вэ? Энэ талаар та тайлбарлаад, тэр шүүхийн тухай хуулийг тайлбарлаад, яагаад манай Монгол Улсын дээд шүүх энэ талаар ярьдаггүй юм бэ? Та нар яагаад үүнийгээ олон түмэндээ тайлбарлахгүй байна? Ард иргэд ингээд үйлчилгээ авах гээд очиход шүүх танхим байхгүй. Хэдэн жилээр хүлээдэг. Яах вэ, сүүлийн нэг жилд арай дээрдэж байна. 2019 онд хуулийг бас өөрчлөөд, заагаад манай Сайнзориг гишүүн сая хэллээ. Үүний дагуу сая Нээлттэй нийгэм форумаас арай дээрдэж байна гэсэн ийм дүгнэлт авсан байна лээ. Нэг функтээр.

Ингээд арай дээрдэж байгаа, арай сайжирч байгаа. Гэтэл нөгөө шүүхийн байр, энэ хүнд суртал, энэ юмаараа манайх ерөөсөө хамгийн сүүлийн байранд байгаа шүү дээ. Үүнийг бас хэлж, ярьж, энэнээс ингээд засах ёстой. Энэ талаар бас Шүүхийн ерөнхий зөвлөл энэ талаар сайн танилцуулаач ээ. Хуулийн зүйл заалт нь ямар байдаг юм тэрийг сонсьё. Энэ надад зориулаад биш олон түмэнд зориулаад, энэ гишүүддээ зориулаад, яг ийм ийм зүйл заалт байдаг юм шүү гэдгийг хэлээд өгчих хэрэгтэй гэж ойлгож байна.

Нөгөө талаар Цогтбаатар дарга эх үүсвэрээ өөрчлөөд, эхнийхээ санал, таны эхний санал хураалтаар явъя. Засвар хийгээд 25 ондоо дуусахгүй бол өмнө нь он дамжуулаад явсан юм

яадаг байлаа. Хамгийн наад зах нь Улаанбаатар гэхэд 2 талынхаа бүстэй нэг 1 шаардлага хангасан байртай болж авъя. Тэгэхгүй бол тэр шүүгч нь нэг хаалгаар орох ёстой, хохирогч нь нэг хаалгаар орох ёстой, нөгөө бүх зааланд зөвлөлдөх танхим нь тусдаа байх ёстой гэсэн ийм юмнууд байна. Тийм юм хангахгүй шүү дээ.

Тэр байтугай Хууль зүйн байнгын хорооны гишүүд ажлын хэсэг байгуулж, энэ шүүхийн нөхцөл байдалтай газар дээр нь явж танилцах хэрэгтэй. Тэнд чинь бараг л Нарантуул зах шиг л байгаа шүү дээ. Хуучин ямар байдаг. Нарантуул зах арай дээр болчихсон. Бүр нөгөө Дэнжийн мянгын зах шиг л бид нарыг бага байхад байдаг байсан. Яг л тийм болчихсон тийм байранд л үйл ажиллагаа явуулж байгаа байхгүй юу. Бусад ардчилсан улс оронд бай ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Саяын энэ асуултуудад Оросын консулын газарт Монголын шүүх байрлаж байгаа юу? Энэ ноцтой ноцтой юмнууд асууж байна шүү дээ. Энд хариулъя. Ажлын хэсэг Энхбилэг даргын микрофоныг өгье. 5 дугаар микрофон.

Л.Энхбилэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Улсын дээд шүүх яагаад энэ талаар ярихгүй байгаа юм бэ гэдгээс нь эхлэх гэж байгаа юм би. Яагаад гэхээр, Улсын Дээд Шүүх бол шүүн таслах ажиллагааг эрхэлдэг. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага. Яг энэ шүүхийн байрны төсөв мөнгөтэй холбоотой асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл чиг үүргийнхээ дагуу хэрэгжүүлж явж байгаа юм. Шүүхийн

ерөнхий зөвлөлд анхан болон давж заалдах шатын шүүхийн нийт 116 шүүх, шүүх байгуулах хуулиар бид нар 88 шүүхтэй болсон. Нийт 42 Тамгын газар байгаа. Энэ бүх шүүх, Тамгын газрын шүүн таслах ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг Шүүхийн ерөнхий зөвлөл хангах ёстой. Үүнийхээ дагуу бид нар ингээд төсвийн талаар бас Байнгын хороо бусад байгууллагатай хамтраад ажиллаад байгаа юм. Та бүхэн бас нөхцөл байдлыг маш сайн ойлгож, газар дээр нь бас үзэж танилцсан учраас би дэлгэрэнгүй ярихгүйгээр, хууль асуусан.

Шүүхийн тухай хуулийн 5.6-д шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана гэж байгаа юм. 48.3-д нь шүүх улсын төсвөөс санхүүжнэ, шүүхийн үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. 46.8.3-д Засгийн газар шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ ээ гэсэн ийм хуулийн зүйл заалтууд байгаа. Энэ дагуу хавар Байнгын хороогоороо яваад, манай төсөв хянагдаад, нийтдээ 420,8 тэрбумаар явсан. Засгийн газар дээр очоод хөрөнгө оруулалт 100,6 тэрбумаар хасагдсан. Хасагдсан юман дотор нь энэ барилгууд орж байгаа, тоног төхөөрөмжүүд орж байгаа. Яах вэ, ингээд хасагдсаныг нь бид нар бас улс орныхоо эдийн засгийн байдал, бусад нөхцөл байдлуудыг ойлгоод, Байнгын хороон дээрээ дахиж бас жагсаалт гаргаад 71,9 болсон. Одоо 71,9-өөсөө бас л ахиад багасах гээд. Бид нар нийтдээ энэ чинь 13 барилгын асуудлыг бид нар энд төсөвлөсөн юм. Эндээ давхарлах ажлууд байгаа, их засварын ажлууд байгаа. Үүнийгээ бид нар бас энэ оныхоо төсвөөсөө хасуулах саналыг нь дэмжээд, одоо яг саяын

Байнгын хорооны даргын дурдсан энэ шүүхүүдэд зайлшгүй байр шаардахад, бид нар яг эрэмбэлж байгаа байруудаа. Одоо нийслэлд 3 байр, орон нутагт 3 гээд ингээд эрэмбэлж байгаа. Ерөөсөө энд ялгавартай байдал гаргаж, аль нэг газраа тийм шүүн таслах ажиллагаа хэвийн явуулахгүй байх нөхцөлийг алдагдуулахгүй байх талаас нь л эрэмбэлээд байгаа юм.

Архангай бол яалт ч үгүй орон нутгийн захиргааны байгууллагын бөөрөнд 2, 3 давхарт л байдаг юм. 1, 2 давхар. Дээр нь Боловсролын газар гээд. Тэгтэл Шүүхийн тухай хуульд шүүхийн байранд өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно оо гэгчихсэн.

Тэгээд бид нар прокурортой хамт байгаад л байгаа. Прокурор байр бариад л, гараад л, бид нар тэр гарсан давхруудыг нь аваад л, засварлаад л юу шүүх хуралдааны танхим хийгээд л. Ингээд орон нутагт, бас харьцангуй орон нутагт бас шүүн таслах ажиллагаа бас боломжийн гэж бид өөрсдөө үзэж байгаа байхгүй юу. Энэ олон жил ажиллачихсан, ийм, тийм эдийн засгийн ийм их хүнд нөхцөл байдалд байгаа учраас боломжийн л гэж өөрсдөдөө үздэг.

Нийслэл бол үнэхээр хүнд. Та нар яваад үзээрэй, нээрээ. Одоо бид нар Кино үйлдвэрийн үзвэрийн танхимд шүүх хурал, шүүх үйл ажиллагаа явуулж байгаа шүү дээ. Тэгээд сая Хуульчдын холбоо саявтар бас ингээд нээлттэй ажлын байрны танилцуулга хийсэн. Энэ хэвлэл мэдээлэл, ард түмэнд нээлттэй. Тэгээд энэ дээр бас нэг дорвитойхон шиг нэг төсвийг минь тавиад өгөөч ээ гээд л хүсээд байгаа юм.

Одоо бид нарын хүсээд байгаа юм бол миний яг хэлэх нь 50,9. 71,9-өөс 50,9. Гэхдээ, гэхдээ бас ингээд юу,

ойлгоод 23 гэлүү, тийм, 23 дээр очиж байгаа. Энэ дотор саяын дурдсан барилгуудыг 3-ны 1 буюу 40 хувиар, дээр ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Ганбат гишүүнд 1 минут байна өгье.

Д.Ганбат: Үгүй ээ, үгүй. Та ойлгоод л, эд нар ойлголцоод л, ийм юм байхгүй шүү дээ. Хуулийнхаа дагуу л яв л даа. Тэр шүүхийнхээ байрыг яг байр шиг байр болгоод нэг хэдхэн байртай болгоод ав л даа. Тэгэхгүй байж байж, ямар юмны шүүхээс шударга ёс шаарддаг юм. Тэр консулын, гадаадын консулын байранд байрладаг нь үнэн юм уу. Миний ойлгож байгаагаар тэрийгээ та хэл. Худлаа юм уу би худлаа юм асуучихсан юм шиг болох нь аягүй бол.

Хан-Уул дүүргийн шүүх түрээсийн байранд байдаг гэж би дуулсан. Би яагаад үүнийг мэдээд байна вэ гэхээр аль 10 жилийн өмнөөс нэг шүүхийг тэр хуульд заасны дагуу шүүх засаглал болгочихын төлөө л яваад байгаа шүү дээ. Энэ олон жилээр ингээд хаягдаж байна.

Тэгээд Улсын Их Хуралтай тохирдог, та нарын байдлыг ойлгоод энэ тэр гэсэн, тийм юм байхгүй ээ. Энэ төсөвт чинь 35 аравны их наяд. Ийм данхайсан төсөвтэй байгаа. Тэгээд хэчнээн тэр авлига, хээл хахууль явж байна. Үүнийг шийдэх ёстой шүүхийн байгууллага, бид нарыг тийм дэд бүтцээр хангаж өгөөгүй учраас бид нарын нөхцөл байдал ийм байна гэж хэлбэл бид нар яах юм. Тэгж болохгүй шүү дээ. Ер нь бол.

Д.Цогтбаатар: Тодруулаад хариулъя. Тэр Дарханы юун дээр. Энэ ард иргэд мэдэж байх ёстой. Та тэрийг нь хариулах хэрэгтэй. 5 дугаар микрофон өгье.

Л.Энхбилэг: Дарханы шүүх яг үнэн. ОХУ-ын түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулаад олон жил болж байна.

Хан-Уул мөн сая Хан-Уул дүүргийн ЗДТГ нурах гэж байгаа хуучин 2 давхар барилгад үйл ажиллагаа явуулж байгаад сая нураасан. Тэгэхэд нь бид нар Хан-Уулын иргэний шүүхийнхээ урд талд бас иргэнээс, түрээсээр 3 давхар объектыг аваад, засварлаад, ингээд шүүхээ оруулчихсан явж байгаа.

Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн шүүх нэгдээд 1 шүүх болох ёстой, иргэний шүүх. Тэгтэл энд орох байр байхгүй. 3 талдаа үйл ажиллагаа явуулж байна. 3 талдаа явуулахдаа мөн л түрээсийн байранд. Тэгээд 25 оны 1 сарын 1-нд тойргийн шүүх болон нэг дор байрлаж, үйл ажиллагаа явуулах ёстой. Тэгтэл 3 газар. Тэгээд нэгдээд 1 орчихъё гэсэн байр байхгүй. Тэгээд л бид нар 25 ондоо ямар ч байсан суурин цутгалтаа хийгээд л ингээд л ажлаа эхлүүлбэ. Болж өгвөл ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Зөв, зөв. Түрүүн Ганбат гишүүний асуултад энэ нөгөө яагаад Дээд шүүхийнхэн ирэхгүй байгаа гээд. Энхбилэг дарга хариулчихлаа. Энэ чинь нөгөө ёстой хараат бус байлгах гол механизм нь. Тэгэхгүй бол тэд нарыгаа энд ирж суулгаж байгаад энэ төсөв яривал бүр нөгөө шүүхийн хараат бус байдал чинь хүнд болно. Гэхдээ Ганбат гишүүний асууж байгаа юм яг зөв шүү. Юу гэвэл байна шүү дээ. Манай байнгын хорооны гишүүд, ялангуяа шинэ гишүүд та нар шүүх төсвөө батлуулах гэж юун дундуур орж байгааг та нар харж байгаа биз.

Тэгээд үүний дараа хараат бус гээд ярих гэхээр маш хүнд байгаа биз дээ. Тийм учраас Байнгын хороо дээр үүнийг чинь баталж өгч, өөрөөр хэлбэл,

хэн нэгэн сайдын, хэн нэгэн даргын, хэн нэг Ерөнхий сайдын үүдийг сахихгүйн үүднээс үүнийг чинь Их Хурал дээр авчирч, Байнгын хороо хороон дээр олонхоороо олуулаа шийддэг газар авчирч, нэг хүний өмнө суулгаагүй байхгүй юу. Ерөөсөө л тэр Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцээд байдаг гол юм нь энэ. Шүүхийн нэг ёсны хараат бус байдлыг нь хангах гээд Сангийн яам нь л энэ Шүүхийн ерөнхий зөвлөл байхгүй юу. Эд нар чинь тэгж төсвөө тийм утгаараа оруулж ирээд байгаа юм. Тэгээд үүнийгээ тийм учраас бид нар цаашидаа ч Хууль зүйн байнгын хороо өөрийнхөө энэ байр суурийг хатуу барьдаг байх ёстой.

Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Монгол Улсад мөнгөнөөс их юм алга даа. Зүгээр мөнгөө юунд зарцуулах вэ гэдэг дээр л бодлого алга гэж би хэлэх гэж байгаа юм.

Өмнө нь энэ Сангийн сайд Хүрэлбаатар байхдаа энэ шүүхийнхнийг үүдэндээ суулгаад тамладаг байсан юм. Тэгээд өнгөрсөн 4 жилд Цогтбаатар дарга байсан, Энхбаяр байсан гишүүн тийм ээ, бид ярьж байгаад, үүнийг нэг сайд, шүүх засаглал чинь нэг сайдаас мөнгө гуйдаг байх юм бол яаж явах вэ дээ гээд.

Тэгээд манай Байнгын хороон дээр татаж ирсэн юм. Одоо манай гишүүд эрхээ эдлэх хэрэгтэй. Энэ Жавхлангийн мөнгө биш байхгүй юу. Энэ чинь татвар төлөгчдийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгийг бид нар энэ зохицуулах, зарцуулах ёстой юманд нь зарцуулах эрхээ эдэлмээр байгаа юм.

Тэгэхдээ би бас нэг юм гайхаад байна. Би Ганбат гишүүнтэй санал нэг байна. Одоо та нар байна шүү дээ, нэг

их олон объектод амсуулах төдий юм хийнэ ээ л нөгөө үнийн өсөлт болоод л ингээд хэдэн жил дамждаг. СХД дээр би сая очоод сургуулиудыг явж үзлээ. 3 сургууль 18 онд эхэлсэн сургууль өнөөдрийг хүртэл ороогүй 6 жил. Та нар ингээд олон юм эхлэх тусмаа л жоохон хутгана гэж ойлго.

Тийм учраас 12 онд Тэмүүжин сайд байхдаа Яармагт нэг ийм том шүүхийн үйлчилгээний байшин барья гэж эхэлсэн юм. Одоо тэрний газрыг нь хувааж идээд дууссан. Орон сууц барьчихсан байна лээ. Та энэ цаасаа өгөхгүй юм. Их Хурлын гишүүд энэ цаас авч байж бид нар мэдээлэл яримаар байх юм. Одоо хаана гэнэ ээ барина, хаана барих гэж байгаа юм. Үгүй ээ зөв биш, хэл л дээ, хаана барих гэнэ. Би, чи уншихаад байгаа юмыг чинь би мэдэхгүй байна шүү дээ. Биш ээ биш. Энэ Яармагт барих гэж байсан цогцолбор хаашаа явж байгаа юм бэ гэж асууж байгаа юм. Яармагтаа барих юм уу? Биш ээ, тэр нэг цаана нь яриад байна шүү дээ. Та Номтын ам ч гэнэ үү нэг юм яриад байх юм. Хаана барих гээд байгаа юм? Үгүй ээ, наад цаасаа өгчих л дөө. Энэ та нар чинь бүх юмыг нууц хийнэ. Үгүй ээ, ядаж тэгээд ил болохоор нь цаасаа өгөхгүй.

Хан-Уул дахь шүүхийн цогцолборт ингэж амсуулж болохгүй ээ. Хан-Уулынхаа шүүхийн цогцолборыг л бариад дуусгамаар байна. Хөөе, манай шүүхийнхэн ч гэсэн, та нар боль л доо. Тэр аймгийнхыгаа нэг аргалчих л даа. Ер нь ингээд 1 юм уу 2 объект дээр мөнгийг нь тавиад дуусгаж сур л даа. Олон газар ингээд суурь тавиад, алж байгаа шүү дээ. 19 оны төсөв дээр Хүрэлбаатар байхдаа 754 төгрөгийг 1,5 их наяд болгоод, маш олон суурь тавьсан. Тэр суурь өнөөдөр хүртэл босохгүй байгаа. Жавхлан мэдэж байгаа шүү дээ. Одоо Сонгинохайрхан дээр 3 сургууль босоогүй байгаа. 9

сарын 9 сард 1-нд эхэлдэг байхад одоо 100, 200 сая төгрөгийн шаардлагатай. Зарим нь 4 тэрбум гээд гараад ирчихсэн. Ингээд ингээд босохгүй байгаад байгаа.

Тийм учраас үүнийгээ миний санаа бол ийм их олон жижигхнээр нь ингэж салгамааргүй байна. Цөөхөн юманд, цөөхөн юманд ингээд тавиад, бодитой дэмжлэг хийчихмээр байна. Тэр Хан-Уулд ээр босгох гэж байгаа цогцолборыгоо үнэхээр босгочихмоор байна. Тэрний чинь суурийг нь тавиад, манай үед ухаад эхэлсэн байхгүй юу. Компани нь шалгараад, зураг бүх юм нь бэлэн. Яг л барууны стандарт, яг шүүхийн үйлчилгээний байгууллагын тэр стандартыг бүгдийг нь хангасан. Ийм юм шүү дээ. Тэгээд та нар хажууд нь ингээд нэг Дархан-Уулын, Багануурыг нь ингээд нэг баахан юм чирж орж ирээд тэгээд өөх ч биш, булчирхай ч биш, боссон ч биш, босоогүй ч биш нэг ийм хуучин, хуучин юм руугаа орж ирээд.

Би энэ мөнгөнүүдээ больё гээгүй. Энэ олон жижигхэн юмнуудаа болиод нэг Хан-Уулынхыгаа босгочих. Би Ганбат гишүүнтэй нэг санал нэг байна. Илүү мөнгө гараад байгаа бол тэр зүүн талынхыгаа босгочих. Зүүн талд бас дахиад нэг юм босгоё гээд байгаа шүү дээ. Шүүхийн үйлчилгээний цогцолбор. Одоо ингээд та нар яг юман дээрээ төвлөр л дээ. Тэгээд хэдүүлээ ингээд нэг бодитой юм хийчихье. Би энд тодорхой санал хэлж байна. Би бол гишүүн ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Энэ дээр оруулсан саналтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Жавхлан гишүүнээр тасаллаа.

Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Уг нь эхнээсээ хуулийн дагуу явж байсан. Тэгээд энэ хууль яаж явах ёстой вэ гэж бид нар ч бас ойлголтоо авчих шиг боллоо. Төсвийн байнгын хороо ч гэсэн харж байгаа байх. Ер нь бас олон түмэн ч гэсэн ойлголт авч байгаа байх гэж ойлгож байна.

Гэхдээ ингээд 1 наймаалцаж байгаа юм шиг юм яриад байж болохгүй ээ. Буцаалаа. Эх үүсвэрээ л бид нар солих ёстой л байхгүй юу. Эх үүсвэр чинь болохгүй байна л гэдэг яриа явагдчихсан. Гэтэл манай Цогтбаатар дарга 1 дүгээрт, 25, 26 оныг дамнуулахгүй ээ, миний санал шүү. 25 ондоо дуусгая. Энэ ажлуудыг 1.

2-т нь, тэр 20 хэд, 30 хэд биш. Тэр төсвийн ерөнхийлөн захирагчаас бас гаргаад байгаа тэр 50 хэд биш, анхнаасаа 70 байсан байхгүй юу. Тэр 70-аар нь явуулъя. Тэгвэл тэр хуульдаа нийцнэ ээ. Ийм санал би гаргаж байна шүү. Үүгээр хураалгаж өгөөрэй. Өмнө нь ч ингээд явж байсан. Их Хурал дээр юу нь болохгүй байна вэ гэдэг яриа явагдсан гэхээр эх үүсвэр нь болохгүй байна. Төсвийн байнгын хороон дээр эх үүсвэр нь болохгүй байна гэсэн. Сангийн сайдтай зөвшилцөөд эх үүсвэрийг нь бид нар шийдчихлээ.

Тэгэхээр үүнийг нь үүнийх нь дагуу тэр 70 тэрбумыг нь батлаад өгчихье.

1 дүгээрт, тэр Хан-Уулдаа баригдах ёстой.

2 дугаарт, бас энэ 2 талыг бүсчлээд байгаа байхгүй юу. Энэ зүүн бүсэд ч бас баригдах ёстой. Тэр Дарханд, өшөө Багануурт, тэр Өмнөговьд тэр нэг 10 аравхан тэрбум юм билээ л дээ. Энэ олон том төсвийн хажууд бол. Тэрийг нь ингээд дуусгаад, дуусгаад барьчихад стандарт

шаардлага хангасан ийм байшин шүүхийн байр, манай нөхцөлд шүү дээ. Яг тэр дэлхийн хэмжээнд яривал байхгүй шүү дээ, бас. Ийм нэг 5, 6 байртай болох юм. Тэрийг нь хэдүүлээ ингээд дэмжээд өгөөд хуулийнх нь дагуу явуулчихъя.

Цааш, цаашидаа хэн нэгэн дарга нараас хамаардаг ийм шүүхийн байшин барилга, шүүхийн төсвийг ярьдаг ийм юмаа больё оо. Уг нь хуулийнх нь дагуу зөвшдөгөөр нь зөвшчихөөд бид нар эндээ ярьдгаар нь яриад, ингээд явуулдаг ийм байя. Энэ ирж байгаа 4 жилд ядаж шаардлага хангасан нэг 20, 30 байртай болж авахгүй л бол энэ иргэд маань аягүй их чирэгдэж байна. Бид нар чинь зах зээлийн системд ороод хуулийн орчин нөхцөл өөрчлөгдөөд, ийм болчихсон учир иргэд үйлчлүүлдэггүй шүүх гэж алга болчихсон байна. Иргэний хэргээ шийдүүлж байна. Тэр гэрлэлт, өмч хөрөнгө өмчлөх, байшин барилгын маргаан гээд ийм олон асуудлууд байдаг. Бид нар ингээд ахиц гараад байгаа байхгүй юу. Уул нь арваад жилийн өмнө Хууль зүйн байнгын хорооны дарга байхдаа АН байхад, Ерөнхий сайд Алтанхуяг дарга байхад үүнийг бид нар иж бүрэн хийж байсан юм. Их өндөр байсан юм. Сүүлийн үед арваад жил унаж байгаад 19 оноос Ардын нам бас нэг энэ учрыг ойлгоод, хэд хэдэн хуульдаа гайгүй өөрчлөлт хийгээд, одоо нэг ганц нэг функтээр ахиад байгаа юм.

Тэгээд 3 нам нийлсэн нэгдсэн гээд л олон юм яриад байгаа. Харин ч нийлэхээрээ дорддог юм шиг ийм байж болохгүй ээ гэсэн ийм зүйлийг ярья.

Тэгэхгүй бол аль болохоор л шүүхийг гартаа атгаж байх, ямар нэгэн юмаар хараат байлгах, ямар нэгэн юм гуйгаад, хэлээд биелүүлснийхээ дараа эргээд нөлөөлдөг.

Ингээд хууль бүхэлдээ зөрчигдөөд байгаа байхгүй юу.

Тэгээд энэ хөрөнгө оруулалт, энэ бүх юмнууд чинь бүгд байхгүй болоод байгаа байхгүй юу. Тэгээд шүүх ч зарчмынхаа дагуу ажиллаж чадахгүй, хар л даа тэр гаргаж байгаа шийдвэрүүдийг нь. Нэг 10 хэдэн саяар торгож байна. Авлигачид баясаж байна шүү дээ. Тэр нь юундаа байдаг юм, прокурортоо байдаг юм уу, цагдаадаа байдаг юм уу, шүүхдээ байдаг юм уу гэдгийг бид нар ахиж үзэх ёстой. Улсын Дээд шүүхийг би яагаад энд яриад байна вэ гэвэл энэ талаар нөгөө хэн сургалт тэр юм нь тэдний мэдэлд байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэд нар тэрийгээ тайлбарлаж таниулж, ард түмнийг бас гэгээрүүлж байх ёстой байхгүй юу. Ийм учиртай юм. Бид нар ийм ийм. Тэр байтугай бид нар энэ чигээр нь явуулаад ингэх юм бол ҮХЦ-ээр унана шүү дээ. Энэ улсын ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Гишүүд маань энэ удаагийн төсвийн хэлэлцүүлгийн дундуур ийм боломж гараад асуудлыг нэг нэлээн тийм ахиулаад шийдчихье гэж байгаа энэ Цогтбаатар даргын гаргаж байгаа саналыг ингээд дэмжээд, саналаа өгчхөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Яах вэ, шүүхэд аль нэг нам нь илүү хайртай гэсэн ойлголт байхгүй байх. Энэ бүгд л шийдэхийн төлөө явж байгаа. АН-ын үед ингэсэн тэгсэн гэдэг юм яриа байж болохгүй. Энэ чинь аль, аль талдаа л шийдэх гээд явж байгаа.

2 дугаарт, яах вэ, би зүгээр Ганбат даргын юун дээр нэг ганц зүйлийг хэлчихмээр байна. Хэдүүлээ

ингээд шүүхийн хууль хэрэглээний асуудлыг мэдэхгүй байж байж хамаагүй ингээд бас яриад байж болохгүй. Тухайн тэр авлигын хэрэг шийдэгдээд явж байгаа хүмүүс чинь тухайн тэр гэмт хэргийг үйлдсэн цаг хугацаанд ямар хууль үйлчилж байсан, тэнд байсан ялаар авч байгаа байхгүй юу. Тийм учраас зарим нь торох ялтай байгаа юм. Энэ торох ялтай хуулийг чинь 15 онд Ганбат дарга маань Байнгын хорооны дарга байхдаа баталсан хууль байхгүй юу. Сүүлд үүнийг та бас өөрөө зассан. Улам чангаруулсан хорих ялтай болгосон.

Тэгэхээр хэдүүлээ ингээд шүүх засаглалыг ингэж хууль хэрэглээний болон тухайн гэмт хэргийг гарсан цаг хугацааг мэдэхгүй байж байж, олон нийтэд ерөөсөө болохоо байчихсан мэтээр ингэж мессеж, сигнал өгдгөө больё оо. Тэгээд энэ шүүхийн барилгыг эхлүүлээд явъя гэж Засгийн газрын бас санаачилга гарч байна. Хууль зүйн байнгын хорооны гишүүд маань бас энэ дээр нь бас ойлголцоод дэмжье гэж байна.

Би өөрөө энэ бас Шүүхийн тухай хуулийг өөрөө гардаж бичсэн хүн байхгүй юу. Яг би энэ хуулийг тайлбарлаад л Алтанхуяг дарга, Сандаг-Очир гишүүн энэ тэрд тайлбарлаад сууж байсан, санаж байна. Харьцангуй энэ зарчмыг нь эвдээгүй төрийн аудитад байгуулах энэ зарчмаар холбогдох Байнгын хороо нь бас төсвийг нь хянаад Засгийн газрын хараат бус, Засгийн газраас хараат бус байдлаар төсөв санхүүгийн хувьд ажиллах бололцоог нь бүрдүүлье ээ гэдэг л ийм заалт байсан.

Яах вэ, хэрэгжих хугацаа дээр наана цаана янз бүрийн юм гарч байна. Үүнийгээ хэдүүлээ сайжруулаад явъя. Тэгээд энэ удаагийн энэ зарчим дээр нь Цогтбаатар даргын энэ саналаар би

ингээд Байнгын хорооны гишүүд маань дэмжээд өгөөч ээ. Аль ч үгүй болчих вий дээ. Ямар ч байсан энэ шүүхийн барилгуудыг хэдүүлээ нэг эхлүүлээд, шүүн таслах үйл ажиллагааны энэ чанар хүртээмж, энэ шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдийн эрх ашиг шүү, иргэдийн эрх ашигийг хэдүүлээ бодолцоод, энэ ажлуудын нэг зарчмын хувьд дэмжээд өгчихье өө гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Би дэмжиж байгаа аргументаа бас нэг тайлбарлах гээд үзээдэхье. Шүүхийн чиглэлийн төсөв гэдэг бол бусад байгууллагын төсвөөс маш өөр өө. Бас энэ дээр юу гэдэг юм мөнгө төгрөг нэмлээ, барилаа гэдэг шүүмжлэл ч юм уу, эс үгүй бол ойлгохгүй зүйлүүд гарч болзошгүй учраас. Яагаад гэхээр энэ засаглалын энэ тэнцвэртэй харилцан хяналт энэ чекин баланс буюу гүйцэтгэх засаглал, хууль тогтоох, шүүх гэсэн энэ 3 эрх мэдлийн нэг салаа мөчир гэдэг утгаар нь энэ шүүхийн төсөв дээр хандах ёстой болчихоод байгаа юм. Тэгэхгүй болохоор ингээд энд ирээд би ийм юм хүсэж байна, бараг тийм юм гуйж байна гэдэг хандлагаар ерөөсөө хандаж болохгүй. Энэ бол зарчмын асуудал байхгүй юу.

Монгол Улс Үндсэн хуультай орон, парламентын засаглалтай. Тэгээд дээрээс нь шүүх нь өөрөө бие даасан хараат бус, шударга, ёсыг сахиулж ажиллана гэдэг зүйл дээр төсөв дээр нь ялангуяа Улсын Их Хурал дээр ямар нэгэн хувь гишүүд популизм хийдэг ч юм уу ийм шантааж хийж болохгүй гэж бодож байна. Тэр утгаараа энэ шүүхийн төсөв гэдгийн цаана түрүүн Сайнзориг гишүүний хэлээд байгаа хүний эрхийн зөрчлийг бууруулах, багасгах, шүүх шударга ажиллах энэ

бүх зүйл маань холбоотой юм. Тэр утгаараа ялангуяа тэр хөдөө орон нутагт ажиллаж байгаа шүүгчдийн үйл ажиллагааг хуулийн дагуу шударга явуулах энэ бүх зүйл дээр энэ төсвийг нь бид нар ингээд зарчмын хувьд тавьж өгөх нь зөв өө гэж бодож байгаа.

Тэгээд ихэнх Хууль зүйн байнгын хорооны гишүүд ч гэсэн ийм саналтай байх шиг байна. Бусад Улсын Их Хурлын гишүүд маань ч гэсэн бас энэ учир начрыг нь тунгаагаад, төсөв гэнгүүт нь нөгөө байдаг нэг байгууллагын төсөв нэмэх гээд байна ч гэдэг юм уу, энэ асуудлаас ялгаж ангид авч үзээрэй. Энэ зүгээр нэг барилга байшин барих гээд байгаадаа биш, цаана нь байгаа энэ системээ бид нар эрүүлжүүлэхэд чиглэсэн том алхам шүү гэдгийг бас нэмж хэлмээр байна.

Тийм учраас үүнийг дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Жавхлан гишүүн саналаа хэлэх үү.

Б.Жавхлан: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Ганц нэг зүгээр ийм зөрүүтэй ойлголт байх шиг байна шүү. Энэ орж ирж байгаа, яригдаж байгаа асуудлыг Засгийн газар санаачлаагүй. Тэгээд үүнийг ялгаж салгаж ойлгоорой. 9 сарын 1-нд 25 оныхоо төсвийг өргөн барихад энэ асуудлуудыг Монгол Улсын Засгийн газраас өргөн бариагүй. Өөрөөр хэлбэл, бид ирэх жил шинээр барилга эхлүүлж амжихгүй ээ, 26 оноос энэ рүүгээ орё. Замаа барья, эрчим хүчээ барья л гэдэг ийм төсөв өргөн барьсан байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн хуулиа барьсан гэсэн үг. Шүүхийн хуулийг биш.

Харин Хууль зүйн байнгын хороо дээрээ энэ саналууд гарч ирсэн. Төсвийн байнгын хороо дээр унасан. Улсын Их Хурал дээр асуудал дахиж яригдаад

өөрчлөн найруулах гэсэн ийм чиглэл Улсын Их Хурлын даргаас орж ирсэн учраас Хууль зүйн байнгын хорооны өмнөх гарсан бас саналд бид хүндэтгэлтэй хандаж байгаа. Ингээд өмнөх саналуудад Засгийн газрын үйл ажиллагааг зогсох, доголдох эрсдэлтэй ийм эх үүсвэрүүдийг бас дурдсан байсан.

Ийм учраас бид асуудалд хүндэтгэлтэй хандаж байна. Тийм. Үүнийг ингээд Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж байгаад бид хүлээцтэй байна. Ийм л зүйл байгаа.

Бусад нь тэр техникийн асуудал байна. Тэр бүтнээр нь оруулж ирээд одоо гэнэт хайртай болоод тэгээд дэмий дээ. Тэр бол харин бүр ёстой 27 он руугаа шилжүүлчхэж магадгүй. 25 онд бүтэн тавилаа гээд тэр ажил нь дуусахгүй байхгүй юу, дуусгаж чадахгүй. Гэтэл 27 онд, 25 онд бүтэн тавьчихаар 26 онд байхгүй болчихно.

Тэгээд 25 онд дуусдаггүй юм гэхэд 26 онд ч мөнгө байхгүй, санхүүжилт байхгүй. Яагаад гэвэл 25 онд бүтэн тавьчихсан учраас жинхэнэ 27 руугаа яваад өгнө. Мэдэж байгаа юм байж байж, хорлож байгаа юм шиг ингээд нэг далд ингэж бас хэрэггүй юм байгаа юм.

Тэгэхээр 2 хуваагдаа л тавьчихна.

Дээрээс нь тэр одоо явж байгаа ажил 13 онд эхлүүлсэн тэр ажлыг тэр дор нь л бараг гацаагаад хаячихсан юм байна лээ. Одоо тэр зураг төсвийг нь шинэчлээд 54 тэрбум төгрөгийн магадлангаар үлдэгдэл санхүүжилт үлдэж байгаа юм. Тэрнийх нь яг талаар нь 50 хувиар нь 25 он дээр 27 тэрбум гээд тавьчихсан байгаа. Өөр хаана ч ингэж байхгүй. 2 хувааж тавьж байсан бид нар тийм дэг юу байгаагүй,

зарчим байгаагүй. Энэ удаа харин шүүх дээр харин ч бүр яг 2 хуваагаад тавиад орж ирж байгаа ийм зүйлүүд байгаа.

Тэгэхээр тэрийг нэг оролдоод хэрэггүй. Үүгээрээ явчих юм бол ямар ч байсан нэг 2 жилийн дотор нэг хэдэн байшинтай болчих юм байна л гэсэн ийм төлөвлөлт юм байгаа юм шүү, тийм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Энд нөгөө Сайнзориг гишүүн энэ миний гаргаж байгаа зарчмын зөрөөтэй санал дээр бас юу хамт санал гаргаж орё гэсэн. Да. Цогтбаатар гишүүн бас орох уу? Тэгвэл ингээд 3 гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргалаа гэж протоколд би бас тэмдэглэж үлдээмээр байна.

Ингээд түрүүн уншиж танилцуулсан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор, уншиж танилцуулсан төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

57,1 хувиар санал дэмжигдлээ.

Энэ дээр Нара гишүүн бас дэмжсэн байна. Үүнийг ингээд нэмээд тооцоорой, Манайхан.

Ингээд санал дэмжигдлээ.

Ганбат гишүүн бас энэ дээр ижил зарчмын зөрөөтэй санал гаргасан. Гэхдээ тоо нь нөгөө өөр байсан. Тэгэхээр яг нэг асуудлаар 2 зарчмын зөрөөтэй санал гаргахад түрүүлж гаргаснаар нь санал хураалгадаг.

*Тийм учраас сая дэгийн тухай
хуулийн дагуу бид нар тэгж санал
хураалгалаа шүү.*

*Ингээд өнөөдөр хэлэлцэх
асуудлаа Байнгын хороо хэлэлцэж
дууслаа.*

13.48 цаг

*Хуралд оролцсон гишүүддээ
талархал илэрхийлье.*

Дууслаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ